



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Авто зам, автотээврийн хяналт зохицуулалтыг
эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн авто зам, автотээврийн хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх зорилгоор Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Загдраднаа, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ё.Жаргалсайхан, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Р.Буд, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон нарт тус тус ДААЛГАХ нь:

Нэг. Авто замын чиглэлээр:

1.1. Овор ихтэй, урт, хүнд ачааг авто замаар тээвэрлэхтэй холбоотой дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

1.2. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчих тээврийн хэрэгслийн тэнхлэгийн даац, бүх жин, овор хэмжээг MNS4598:2020 стандартын дагуу хэмжиж тогтоох ажлыг төлбөр авах цэгүүд дээр байрлах суурин болон явуулын авто пүүг тогтмол ашиглах, хэмжилтийг авч нэгтгэх;

1.3. Зуны улирал болон хавар, намрын улирлын газар хөлдөлт, гэсэлтийн үеэр суурин пүүгүй авто замд зөөврийн авто пүү ашиглан Хөдөлгөөнт эргүүл байнга ажиллуулж хяналт тавих;

1.4. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж буй зөрчлийг таслан зогсоох талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны дотор батлуулж, хэрэгжилтийг хангуулах;

1.5. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/185 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам”-ын 3 дугаар бүлэгт заасны дагуу даац хэтрүүлсэн тээврийн хэрэгслийг гаргасан зөрчлөө засах хүртэл хөдөлгөөнд оролцохыг хориглох, түр саатуулах арга хэмжээ авах;

1.6. Авто зам ашигласны төлбөр авах цэгийн үйл ажиллагааг цахимжуулах, тээврийн хэрэгслийн даац хэмжих автомат пүүг олон улс, улсын чанартай авто замуудад суурилуулах, даац хэтэрсэн тээврийн хэрэгслийг хяналтын төвд тухай

08 000006

бүр мэдээлэх системийг бүрдүүлэх, хянах, мэдээллийг ил тод болгох ажлыг 2021 оны гуравдугаар улиралд багтаан зохион байгуулах;

1.7. Авто замын хяналтын пүүний нэгдсэн систем хөгжүүлэх туршилтын ажлыг зохион байгуулах;

1.8. Хяналт шалгалтын ажилд автотээврийн улсын хяналтын байцаагчдыг татан оролцуулах;

Хоёр. Автотээврийн чиглэлээр:

2.1. Автотээврийн улсын байцаагчдыг олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах цэгүүдэд байрлуулж ажиллуулах, “Хөдөлгөөнт эргүүлийн баг”-тай хамтран хяналт, шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлэх;

2.2. Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” 4598:20 20-стандартыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

2.3. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран даац хэтрүүлэн тээвэрлэлт гүйцэтгүүлэхгүй байх шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

2.4. Овор хэмжээ хэтэрсэн хагас чиргүүлд улсын дугаар олгож холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн асуудлыг засаж стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах.

Гурав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих;

3.1. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

САЙД  Л.ХАЛТАР

9020050420 5519487 СБА7589